

ЭЛЭГНИЙ ХАВДРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОМЖТОЙ.

Хепатитийн В, С вирусийн халдвараас сэргийлэх

В хепатитийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдсанаар уг халдвараас сэргийлэх боломжтой.

Хэдийгээр хепатитийн С вирусийн эсрэг вакцин хараахан гараагүй ч халдварыг эрт оношлуулж эмчлүүлсэнээр бүрэн эдгэрэх боломжтой. Ингэснээр элэгний хавдар үүсэх эрсдэлийг бууруулна.

Эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэх

- Архи согтууруулах ундаа, хорт зуршлаас татгалзах
- Зөв зохистой хооллох, жимс хүнсний ногоог тогтмол хэрэглэх
- Дасгал хөдөлгөөн хийж, биеийн хэвийн жингээ хадгалах
- Хөгцөрч муудсан цагаан идээ, хүнсний бусад бүтээгдэхүүнээс татгалзах
- Эм тариаг дур мэдэн хэрэглэхээс зайлсхийх

Хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдах



ЭРҮҮЛ ЭЛЭГ
ТАНЫ АМЬДРАЛ

ЭЛЭГНИЙ ХАВДАР ЭРТ ИЛРҮҮЛБЭЛ ЭМЧЛЭГДЭХ БОЛОМЖТОЙ.

“Вируст хепатит ба элэгний хавдрыг эрт илрүүлэх төсөл” (GG 1529067)-ийн хүрээнд энэхүү мэдээллийг бэлтгэн хэвлүүлэв.

Дэлгэрэнгүй мэдээллийг:
www.fireprojects.org

Rotary




FIRE

Flagstaff International Relief Effort




ЭЛЭГНИЙ ХАВДАР



Улаанбаатар хот
2017 он

“ЭЛЭГНИЙ ХАВДАР” гэдэг нь элэгний эсээс үүсэлтэй хортой хавдар юм. Элгэнд удаан хугацаагаар үйлчилсэн химийн хортой бодис болон архаг ужиг өвчнүүдийн улмаас элэгний хавдар үүсдэг.

Монгол Улс 100 000 хүн ам тутамд элэгний хавдрын нас баралтаар дэлхийд тэргүүлж байгаа төдийгүй энэ үзүүлэлт нь дэлхийн дунджаас ДОЛОО дахин их байна.



Эх сурвалж: WHO GLOBOCAN 2012 (IARC) 9.4.2014


Манай улсад элэгний хавдар нь нийт хавдрын 39.6 хувийг эзэлж хамгийн өндөр тархалттай байна.

Элэгний хорт хавдартай гэж оношлогдсон хүн амын 81.2 хувь нь III, IV үе шатанд буюу өвчин хүндэрч эцсийн шатанд орсон үедээ оношлогдож байна.

Хепатитийн В, С вирусийн халдвар нь элэгний хавдар үүсгэх гол шалтгаан болдог.

Вируст хепатит нь

- Цусаар
- Хамгаалалтгүй бэлгийн хавьтлаар
- Халдвартай эхээс хүүхдэд төрөх үед дамжин халдварлана.



Дараах хүчин зүйлүүд элэгний хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх
- Таргалалт
- Хөгцөрч муудсан хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх
- Эмийн бэлдмэл болон химийн бодис, тэдгээрийн хордлого
- Бодисын солилцоо болон дархлалын эмгэг

Элэгний хавдар нь ихэнх тохиолдолд тухайн хүнд ямар нэг зовиур, шинж тэмдэггүй байсаар хожуу шатандаа илэрдэг тул дараах хүмүүс **“ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ”**-т хамрагдах шаардлагатай.

Үүнд:

- 40-өөс дээш насны эрэгтэйчүүд
- 50-аас дээш насны эмэгтэйчүүд
- Хепатитийн В,С вирусийн халдвартай гэдгээ мэддэг бүх насны хүмүүс
- Элэгний архаг үрэвсэлтэй, элэгний хатууралтай бүх насны хүмүүс
- Элэгний хорт хавдраар өвчлөгсдийн нэгдүгээр үеийн төрөл садан

Элэгний хавдрыг эрт илрүүлэх оношилгоо



- Элэгний хэт авиан оношилгоо

Энэ нь элэгний бүтцийн болон голомтот өөрчлөлтийг илрүүлнэ.



- AFP (альфа-фетопротейн) буюу элэгний хавдрын маркер илрүүлэх шинжилгээ